



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/151

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Швейцарийн Элчин сайдын яамны Хамтын ажиллагааны газартай байгуулсан № 81061081 дугаартай гэрээ, Монголын бэлчээр ашиглалтын нэгдсэн холбооны Худалдан авалтын журмын “Бараа худалдан авалт” хэсгийн 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Швейцарийн Элчин сайдын яамны Хамтын ажиллагааны газартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд “Мал эмнэлгийн гэрчилгээний систем” худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Д.Батцэнгэл	- Мал эмнэлгийн газрын дарга
Гишүүд:	С.Дивангар	-Ногоон алт малын эрүүл мэндийн мэргэжилтэн
	Э.Цолмон	- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
	Ц.Бямбацогт	-Мал эмнэлгийн газрын Захиргаа, санхүүгийн албаны дарга
	Б.Мөнхбат	-Монголын үндэсний мал эмнэлгийн холбооны тэргүүлэгч
	Ж.Батсайхан	-Тогтвортой амьжиргаа 3 төслийн орон нутгийн ажилтан

Нарийн бичгийн дарга:

О.Гантуяа - Аймгийн бэлчээр ашиглагчдын холбооны нягтлан бодогч

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг Монголын бэлчээр ашиглалтын нэгдсэн холбооны "Худалдан авалтын журам"-ын дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Д.Батцэнгэл /-д үүрэг болгосугай.

3. Дээрх худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /О.Гантуяа /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД